



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 17

Өмнөдэлгэр сум

2025 оны байгаль хамгаалах, нөхөн сэргээх
арга хэмжээний зардлыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.2025 онд сумын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний ажлыг 1 дүгээр хавсралтаар, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний ажлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний ажлыг гэрээ байгуулан бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Баярмаа)-д даалгасугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, дэд бүтцийн асуудал эрхэлсэн хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороонд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

D.disc /alban bichig/ ITH togtool



Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
ээлжит Гуравдугаар Хуралдааны 17 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

2025 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх
байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Ажлын хийгдэх хугацаа /сар/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зардлын төрөл			Нийт
					Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах мөнгөн дүн /төг/	Газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах мөнгөн дүн /төг/	Амьтан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах мөнгөн дүн /төг/	
1	Амьтны амьдрах орчинг сайжруулах /булаг хаших/	6	ширхэг	1			2,500,000	2,500,000
2	Нэн ховор амьтанд биотехникийн арга хэмжээ авах	1-2	удаа	2			750,000	750,000
3	Хууль бус амьтан агнахаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллах	1-12	удаа	10			5,750,000	5,750,000
4	Цагаан зээрийг хамгаалах өдөр, тандалт судалгаа урьдчилан сэргийлэх хяналт шалгалт	9-12	удаа	5			1,000,000	1,000,000
5	Хөрсний доройтол мониторинг судалгаа	6	удаа	15		4,500,000		4,500,000

6	Хөрсний доройтол цөлжилтөөс урьдчилан сэргийлэх	5	удаа	10		10,500,000		10,500,000
7	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Мод үржүүлгийн газарт усалгааны систем тавих/	4	га	5	9,000,000			9,000,000
8	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Насны II дугаар ангийн ойд арчилгааны тохируулах ажил хийх/	6	га	20	9,200,000			9,200,000
9	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /ойн дагалт баялаг, ойн нөөц тогтоох дрон зургийн камер авах/	2	ширхэг	2	7,500,000			7,500,000
10	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Ойн цэвэрлэгээ хийх/	1	га	25	3,600,000			3,600,000
11	Хамгаалалтын ойн зурвас байгуулах	5	га	1.7	19,125,000			19,125,000
12	Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт	1-12	удаа	10	2,062,594			2,062,594
	Нийт				50,487,594	15,000,000	10,000,000	75,487,594



Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
ээлжит Гуравдугаар Хуралдааны 17 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

2025 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын давсан орлогын хэсгээр
санхүүжүүлэх байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Ажлын хийгдэх хугацаа /сар/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зардлын төрөл		Нийт
					Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах мөнгөн дүн /төг/		
1	Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаар иргэдэд сургалт зохион байгуулах, идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулах	1-12	удаа	1	35,000,000		35,000,000
2	Доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалт	5	га	20	54,000,000		54,000,000
3	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /мод үржүүлэг, нөхөн сэргээлтийн ажилд ашиглах тээврийн хэрэгсэл авах/	3	ширхэг	1	33,500,000		33,500,000
4	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /мод үржүүлгийн газрын арчилгаа, усалгаа, хамгааллын зардал/	1-12	сар	24	51,500,000		51,500,000
5	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /мод үржүүлгийн газарт мини экскаватор авах/	3	ширхэг	1	45,000,000		45,000,000

6	Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /мод үржүүлгийн газарт тарих мөчир худалдаж худалдаж авах/	4	ш	8000	5,000,000	5,000,000
7	Үүргийн шуршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавжтай тэмцэх	6	га	500	31,500,000	31,500,000
8	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажил хийх	3-6, 9-11	удаа	4	10,000,000	10,000,000
9	Хамгаалалтын ойн зурвас байгуулах	4-5	га	5.3	59,625,000	59,625,000
10	Ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгаа хийх	5-7	удаа	6	2,125,000	2,125,000
	Нийт дүн				327,250,000	327,250,000